

**ОДОО ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛТ АРД ТҮМНҮҮДИЙН  
БИЧГИЙН ХЭЛ, ТЭДНИЙ СОЁЛЫН ХОЛБОО**

**О. Самбуудорж\***

**Түлхүүр үг: Монгол хэл аялгуу, ард түмэн, бичгийн хэл, соёлын холбоо**

**1. Удиртгал.** Энэ өгүүлэлд бид одоо үеийн монгол хэлт ард түмнүүдийн бичгийн хэл, соёлын холбооны талаар өгүүлнэ. Энэ нь монгол хэлт ард түмний хэл аялгуу, өөрийгөө ухаарахуй зэргийг танин мэдэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Монгол хэл аялгуугаар ярилцагчид Ази - Европын өргөн уудам нутагт тархан сууж байна. Монгол хэл аялгууг ангилсан туршлагыг үзвэл аялгуу, аман аялгуу бүхий нэг монгол хэл<sup>1</sup>, аялгуу, аман аялгуу бүхий ойрын болон холын төрөл монгол хэлнүүд<sup>2</sup>, аялгуу, аман аялгуу бүхий тусгай тусгай монгол хэлнүүд<sup>3</sup> гэсэн гурван ангилалд багтдаг байна.

Энэ нь хэл, аялгууны онцлогийг баримтлах, засаг захиргааны хуваарийг баримтлах, энэ хоёр онцлогийн аль алиныг баримтлахтай холбоотой байдаг байна. Хэдий тийм ч бид одоо үеийн монгол хэл, аялгуунуудыг **төв монгол хэл, аялгуу** (халх монгол, өвөр монгол, ойрад монгол, буриад монгол, халимаг монгол, дагуур монгол), **салангид монгол хэл, аялгуу** (баоань, дуншаан, шар ёгур, монгор, могол, канжа хэлнүүд) гэж хоёр ангид хувааж болно<sup>4</sup>. Учир нь эхний ангиллын аялгуутнууд өөр хоорондоо шууд болон бэрхшээлгүй харилцаж чаддаг байна. Хоёр дахь ангиллын аялгуутнууд нь эхний ангиллын аялгуутантай болон өөр хоорондоо харилцахад нэлээд саад бэрхшээлтэй байдаг байна.

**2. Одоо үеийн монгол хэлт ард түмний бичгийн хэл, бичгийн хэлний суурь аялгуу.** Монгол хэл аялгуутнаас одоо үед өмнөх ангиллаар үзвэл төв монгол хэл, аялгуугаар ярилцагчид өөр өөрийн бичгийн хэлийг хэрэглэж байна. Харин өмнө өгүүлсэн салангид монгол хэл аялгуутнууд өөрийн бичиг үсэг бүхий бичиг зохиолын хэлийг хэрэглэж ирсэн баримт тодорхойгүй, ихэнхдээ харьяалагдаж байсан улс орныхоо бичиг үсгийг хэрэглэж ирсэн байна. Гэхдээ дагуур монголчууд монгол бичгийг хэрэглэж байсан, одоо ч их бага хэмжээгээр хэрэглэж байгаа, ялангуяа монгол бичгийг сайн мэддэг дагуур монголын сэхээтнүүд монголын соёлын талаар их зүйлийг хийсэн байна. Түүнчлэн өвөр монгол,

\*МУШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

дагуур монголчууд 1950-иад онд кирилл үсэг, дагуур монголчууд 1930-аад онд латин үсгийг ч авч хэрэглэхийг чармайж байв<sup>5</sup>. Мөн дагуур монголчууд 1980-аад оноос ханз үсэг тэмдэглэх латин галигийг ашиглан өөрийн бичгийн хэлийг бий болгох туршилтыг бас хийсэн байна. Мөн одоо үед Хөх нуурын монголчууд засаг захиргааны хувьд өвөр монголд шууд харьяалагдахгүй боловч монгол бичгийг сургуульд зааж идэвхтэй хэрэглэж байна. Бас Хөх нуурын монголчууд тод монгол үсгийг хэрэглэж ирсэн уламжлал байна. Одоо монгол хэлт ард түмний хэрэглэж ирсэн, хэрэглэж байгаа бичиг үсгийн нэр, он цаг, бичгийн хэлний суурь аялгууг хүснэгтээр үзүүлбэл доорхи байдалтай юм. Энэ нь монгол хэлт ард түмний хэл аялгуу, соёлын холбоог танин мэдэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Улс, нутаг орон	Хэрэглэж ирсэн гол үсэг бичиг	Хэдий үеэс хэдий үе хүртэл хэрэглэсэн	Одоо хэрэглэж буй үсэг бичиг	Бичгийн хэлний суурь аялгуу	Одоогийн бичиг үсгийг хэдий үеэс хэрэглэсэн
Монгол улс	Монгол үсэг	?- 1941 (1946) хүртэл	Кирилл үсэг	Халх аялгуу	1941 (1946) оноос хойш
Өвөр монгол	Монгол үсэг	?-Мөн одоо хүртэл	Мөн монгол үсэг	Цахар,Баарин аялгуу	-Мөн одоо үе хүртэл
Шин-жааны ойрад монгол	Монгол үсэг	?-1648 он хүртэл ба түүнээс хойш ч	1. Тод монгол үсэг 2. Монгол үсэг	Ойрдын аман аялгуу нууд	-1648 оноос хойш одоо хүртэл -1880-аад оноос
Халимаг монгол	1. Монгол үсэг 2. Тод монгол үсэг 3. Латин үсэг	?-1648 он хүртэл ба түүнээс хойш 1648-1924 он 1930-1938 он	Кирилл үсэг	Дөрвөд, торгууд аялгуу	1924-1930, 1938 оноос одоо хүртэл
Буриад монгол	1. Монгол үсэг 2. Латин үсэг	?-1929 он хүртэл 1929-1935	Кирилл үсэг	Хори аялгуу	1936 оноос одоо хүртэл

**3. Одоо үеийн монгол хэлт ард түмний бичгийн хэлний зарим онцлог.** Монгол хэлт ард түмний үсэг бичгийн ийм өөрчлөлт нь тэдний бичгийн хэлийг судлах хэрэгцээ, шаардлагыг аяндаа бий болгож байгаа юм. Иймд монголчуудын бичгийн хэлний тухай өгүүлэхдээ бичгийн хэлний түрүү болон хожим үеийн “а”, “б” гэсэн хоёр хувилбарыг өөр хооронд нь харьцуулж өгүүлэх нь чухал байгаа юм. Учир нь “а” хувилбарын жишээ баримт нь одоогийн бичгийн хэл бүхий тэдний аялгуунд хэрхэн уламжилж буйг, “б” хувилбар нь тэдний одоо үеийн аялгууны хувьсал өөрчлөлийг танин мэдэхэд чухал юм. Үүний тул бид “а” хувилбарт тухайн аялгуунуудын бичгийн хэлээр хөрвүүлсэн “Монголын нууц товчоон”-ы нэг бичил эхийг, “б” хувилбарт одоо үеийн сонины өөр өөр бичил эхийг жишээ болгон харьцуулав.

Нэгдүгээрт, “а” хувилбарын жишээг харьцуулан үзвэл дараах онцлог зүйл ажиглагдаж байна. (Хавсралт 1-ийг үзнэ үү.)

(1) “а” хувилбарыг одоо үеийн монголчуудын бичгийн хэлний аль ч хувилбараар уншихад зөвхөн монгол хэлээр уншиж байна гэсэн нийтлэг зүйл ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл аль ч бичгийн хэлний хувилбарыг төв монгол хэл, аялгуутан сонсоод ойлгох бүрэн боломжтой ажээ.

(2) “а” хувилбарт нийт монголчуудын уламжлалт үгийн сан тухайн аялгуунуудад хадгалагдсан хэвээр байна. Иймд тэдний аль ч аялгуунд үл ойлгогдох үгс үгүй байна. Зөвхөн

зарим аялгуунд идэвхтэй, зарим аялгуунд идэвхтэй бус хэрэглэх монголчуудын уламжлалт үгийн сангийн « **ааших (айсуй, айсихуй), зон (олон түмэн)** » зэрэг үгсийг халимаг болон буриад монголчуудын бичгийн хэлэнд идэвхтэй хэрэглэж байна.

(3) “**а**” хувилбарыг уншихад нутгийн аялгууны авиан зүйн зарим нэг онцлог ялгаа байгаа боловч түүнийг аль ч аялгуутан сонсоод ойлгодог, тэгж ярьдаг гэж боддог, тэдний аман харилцаанд саад болдоггүй авиан зүйн үзэгдэл байдаг байна.

(4) “**а**” хувилбарыг уншихад хэл зүйн талаар нийт аялгуунд илэрхий өвөрмөц ялгаа байхгүй, зарим аялгуунд эгшиг зохицох болон уламжлалт онцлогоо хадгалсан хэлзүйн тогтолцоо байдаг байна. Жишээ нь, харьяалахын тийн ялгалын нөхцөл нь буриад аялгуунд эгшиг зохицох байдалтай, халх аялгуунд үгийн төгсгөлийн авиаг баримталсан хувилбартай, заахын тийн ялгалын нөхцөл нь буриад аялгуунд монгол бичгийн хэлний онцлогийг хадгалсан онцлогтой байна. Жишээ нь:

**Монгол улсын бичгийн хэл:** Дуваа-Сохор/ын/, хүн/ий/, горх(он)/ийг/, дүүтэй/гээ/

**Буриад монголын бичгийн хэл:** Дуваа-Сохор/ой/ хүн/эй/, горхон/иис/, дүүтэе/э/

Хоёрдугаарт, “**б**” хувилбарын жишээг харьцуулан үзвэл дараах зарим зүйл ажиглагдаж байна. (Хавсралт 2-ыг үзнэ үү.)

(1) Нийт монгол хэлт ард түмний дундын үгс боловч ойролцоо утгатай үг, дагавраар сольж хэрэглэх нь бий. Жишээ нь, буриад монголын бичгийн хэлэнд «**амаршалга**» гэснийг монгол улст « **мэндчилгэ/э/** » гэнэ. Шинжааны ойрд монголд « **мэдээч, зангич** », халимаг монголд « **зэнгч** » гэснийг монгол улс, өвөр монголд « **мэдээч, сурвалжлагч** » гэнэ. Өвөр монголд « **сэтгэц тогтоон** » гэснийг монгол улст « **санаа тогтоон, санаа шийдэн** » гэнэ. Бичгийн хэл бүхий олонхи аялгуунд « **гариг, гараг** » гэж төвд гаралтай үгээр бичиж буй үгийг ойрд монголчуудын одоо үеийн тод үсгийн бичгийн хэлэнд « **өдөр** », аман аялгуунд « **гараг, өдөр** », гэсэн үгээр хэрэглэнэ. Халимаг монголчуудын бичгийн хэлэнд « **шүүвр, нэгдгч** » гэж оноон хэрэглэж буй үгийг монгол улсын бичгийн хэлэнд « **шүүлэг, нэгдүгээр** » гэж утга адил дагавраар сольж хэрэглэж байна.

(2) Монгол хэлний бичгийн хэлнүүдэд тухайн аялгууны хүн нийт олноороо, эсвэл бусад аялгууны хүн ойлгохгүй зарим хар. гаралттай үг хэллэг бий болсон байдаг байна. Ийм жишээ нь ихэнхдээ нэр томъёо тогтоохтой холбоотой байна. Жишээ нь, **халимаг монголд:** государственн технолого - экономическ коледжин (Улсын технологи - эдийн засгийн коллежийн), **буриад монголд:** Буряад Республикын Арадай Хуралай V сесси (Буриадын Бүгд Найрамдах Улсын Ардын Хурлын V чуулган), **монгол улст:** прокурор, гааль, татварын байгууллага, систем/тогтолцоо, **ойрад монголд:** сестем (систем/тогтолцоо), кадр (боловсон хүчин), **өвөр монголд:** богц (цүнх), эмийн дэлгүүр (эмийн сан/аптек), цахилгаан дэн (чийдэн) гэх мэт.

(3) Кирилл үсэг хэрэглэж буй монголчуудын бичгийн хэлний аль алинд нь ажиглагдаж буй өөр нэг зүйл бол тэдний зөв бичих дүрмийн ялгаа юм. Тухайлбал, халимаг монголчуудын бичгийн хэлэнд тэргүүн бус үеийн урт эгшгийн тэмдэгтийг үл давхарлан богино эгшгийн тэмдэгтийг үл бичдэг бол халх аялгуунд балархай эгшгийг бичих, бичихгүй, буриад монголын бичгийн хэлэнд ихэнхдээ бичих дүрэмтэй байгаа юм.

**4. Одоо үеийн монгол хэлт ард түмний соёлын холбоо.** Соёл, соёлын холбоо нь олон талт ухагдахуун билээ. Бид зөвхөн энд ярьж буй сэдвийн хүрээнд бичгийн хэл бүхий монгол хэлт ард түмний соёлын холбоог **бичгийн хэлний соёлын холбоо, бусад харилцааны соёлын**

**холбоо** гэж хоёр ангид хувааж болох байна. Учир нь тэдний соёлын холбоо нь бичгийн хэлээр дамжин холбогдохоос гадна соёлын харилцааны бусад олон хэлхээ холбоогоор нөхцөлддөг байна. Монгол хэлт ард түмний уламжлалт соёлын хэлхээ холбоо нь өнгөрсөн зууны 30-аас 90-ээд онд нэлээд уналтад орж одоо энэ байдалд зарим ахиц гарах болжээ.

**5. Бичгийн хэлний соёлын холбоо.** Монгол хэлт ард түмний хэл аялгуу, шүтлэг, зан заншил, тухайн үеийн нутаг дэвсгэрийн харилцан зорчих чөлөөт байдал, уламжлалт монгол бичгийн хэл нь тэднийг хэл аялгуу, соёлын хувьд нэгтгэхэд ихээхэн үүрэгтэй байв. Иймд одоогийн олон бичгийн хэл үүсэхээс өмнө туурвиж бүтээсэн соёлын өв нь тэдний хамтын хүчээр бүтсэн өв хөрөнгө төдийгүй бас тэдний одоогийн олон бичгийн хэл ч уг соёлыг бүтээсэн дэвсгэр суурийн уламжлал гэж болно. Гэхдээ тэд одоо үед өөр өөр үсэг бичиг хэрэглэх болсон нь тусгайлан сурсан хүн л тухайн бичгийн хэлээр уншиж бичих, судалгаа хийх, тийм бус хүн уг бичгийн хэлээр уншиж бичиж чадахгүй, зөвхөн уг бичгийн хэлээр бичсэн зүйлийг өөрийн хэрэглэж буй бичгийн хэлний үсгээр хөрвүүлэн буулгасан ном, бүтээлийг уншиж танилцах байдал бий болжээ. Иймээс сүүлийн үед аль нэг аялгууны бичгийн хэлээр гарсан ном бүтээлийг өөр аялгууны бичгийн хэлэнд хөрвүүлэх байдал нэлээд бий болов. Гэсэн хэдий ч ном хэвлэл унших сонирхол, боломжоор хязгаарлагдмал бүлгийн хүмүүст энэ талын соёлын холбоо хамааралгүй бөгөөд зөвхөн соёлын бусад холбоогоор үүнийг нөхөх боломжтой байдаг байна.

Одоо үед бичиг үсэг хэрэглэж буй монгол хэлт ард түмний бичгийн хэлний шинэ маягийн соёлын холбооны бас нэг онцлог бол латин үсэг хэрэглэн интернетээр харилцах байдал нэлээд бий болжээ. Гэхдээ тэдний хэн нь ч латин үсгийг унших болон латин үсгээр тодорхой зүйл бичиж чадах боловч нэгдсэн дундын дүрэм үгүй тул өөр өөрийн бичгийн хэлний дүрмийг баримтлах, эсвэл монгол улсын кирилл үсгийн дүрмийг баримтлан бичих байдал байна. Энэ нь интернетээр харилцахад тухайн аялгуутны бичгийн хэлтэнд төдийгүй, нийт дундаа нэгдсэн журмаар хэрэглэвэл зохих латин үсэгт суурилсан зов бичих дүрэм хэрэгтэй байгааг харуулж байгаа юм. Ийм байдал нь монгол хэлт ард түмний бичгийн хэлний соёлын холбоонд эерэг нөлөө үзүүлэх нь эргэл зээгүй билээ<sup>6</sup>. Монгол улст энэ сөрөг байдлаас гарахын тулд монгол хэлний кирилл үсгийг латин үсгээр орлон бичих жишгийг 2004 оны 1 сарын 1-ээс эхлүүлсэн билээ. Ер нь монголчууд латин үсгийг хэрэглэж байсан туршлагын талаар нэлээд судалгаа байгаа билээ<sup>7</sup>.

Бичгийн хэл хэрэглэж буй одоо үеийн төв аялгууны монголчуудын дунд бас нэг зүйл ажиглагдаж байгаа нь нэг аялгуутны аман ба бичгийн хэлээр ярьсан, уншсан зүйлийг нөгөө аялгуутан өөр өөрийн бичгийн хэлээр тэмдэглэж авах чадвар юм. Монгол улст зарим хүн монгол бичиг болон кирилл үсгийн аль алианаар тэмдэглэн бичиж бичгийн хэлний суурь аялгуугаар унших зүйл ажиглагддаг болно. Ялангуяа 1950-иад оноос өмнө сургуульд сурч байсан ахмад үеийнхэн хоёр бичгийн аль алианаар сайн уншиж бичиж чаддаг. Ийм хүнийг бид “**хоёр хэлтэн**” гэж ойлгож болохгүй бөгөөд хоёр өөр үсгээр тухайн хэлний нэг эхийг тэмдэглэн бичсэн “**нэг хэлтэн**” гэж ойлгох нь тодорхой юм.

Үүнээс үзвэл ар, өвөр монголчууд хоёр өөр үсэг бичиг хэрэглэж байгаа гэсэн ч тэд бие биеэ болон өөрийгөө монгол гэж дууддаг, зарим нэг салангид аман аялгууг эс тооцвол бие биеийн хэл яриаг төвөггүй ойлгодог байдал нь өнөөгийн төвшинд тэднийг “**нэг эх хэлтэн**” гэж нэрлэж болох байна. Гэхдээ одоо үеийн бичгийн хэл бүхий монголчуудаас бичгийн хэлний

сургалт нь буриад монгол, халимаг монголд нэлээд сул байдаг байна. Энэ нь буриад монгол, халимаг монголд өнгөрсөн зуунд нийтийн (интернационалч) соёлыг чухалчилж, нийгмийн хүрээнд орос хэлний үүргийг хэт өргөмжлөн бас үсэг бичгийн өөрчлөлт хийсэн зэрэгтэй холбоотой байна. Сүүлийн үед хятад улст зах зээлийн нийгмийг дэмжиж, хятад хэлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвшихэд нийгмийн бодлого нөлөөлөх болсон нь өвөр монголд монгол хэл, монгол бичгийн сургалт зарим газар илт хоцрогдох болжээ. Үүнээс үзвэл хүн төрөлхтний түүхэнд цаг хугацааны үйл явц, учир зүйн холбоо зэрэг нь тухайн ард түмний хэл, соёлд нөлөөлж байдаг нь тодорхой юм. Иймд ард түмэн хэл аялгуу, соёлоо хамгаалж хөгжүүлэхэд энэхүү үйл явц, учир зүйн холбоог зөвөөр ойлгож зохицуулах нь даяаршлын энэ үед чухал юм<sup>8</sup>.

**6. Бусад харилцааны соёлын холбоо.** Одоо үеийн бичгийн хэл бүхий монгол хэлт ард түмний энэ талын соёлын холбоо нь бичгийн хэлний соёлын холбоог бодвол харьцангуй өргөн юм. Ийм соёлын холбоо нь албаны харилцаа, худалдаа арилжаа, ард түмнүүдийн төрөл садны болон жирийн уулзалт, сургуульд суралцах, аялал жуулчлалаар явах, урлаг, биеийн тамирын айлчлал зэрэг хүмүүнлэгийн харилцааны олон зүйлээр холбогдож байна. Ялангуяа радио, телевизийг сонсож үзэх нь тэдний энэ талын соёлын холбоонд эергээр нөлөөлдөг байна. Монгол улсын болон өвөр монголын тал нутгийн хүмүүст хоёр орны радио нэвтрүүлэг маш их үүрэгтэй байсан бөгөөд өнгөрсөн зууны 60, 70-аад онд хятад, монголын улс төрийн таагүй харилцаанаас үүдэн монгол улсын болоод өвөр монголын радио нэвтрүүлэг нь үзэл суртлын үүрэгтэй байв. Сүүлийн үед монгол улст хүмүүс дуртай үзэх телевизийн нэвтрүүлгийн нэг бол өвөр монголын телевизийн нэвтрүүлэг юм. Харин монгол улсын телевизийн нэвтрүүлгийг бусад орны монголчууд хараахан үзэж чаддаггүй байна.

Монгол хэлт ард түмний дуу хуур, хөгжим нь тэдний соёлыг түгээх маш их үүрэгтэй гэж болно. Монголчуудын уламжлалт ардын дуунаас гадна, монгол улст шинээр зохиогдсон олон дуу өвөр монголд нийтийн дунд хурдан хугацаанд түгэн тархаж байна. Өвөр монголд зохиогдсон олон дуу ч монгол улст дэлгэрч байна. Үүнд радио, телевиз, аялал жуулчлал, худалдаа, урлагийн айлчилсан тоглолт, бусад харилцаа их үүрэгтэй юм. Бусад монголчуудаас нэлээд алс хол ахуйлан суух Халимаг монголын дуучин Цагаанхаалга-ын дуулсан « Эхийн тусын дуун » гэдэг дуу монгол улст нийтэд түгсэн шилдэг дууны нэг болж байсан нь үүний жишээ гэж болох байна.

**7. Дүгнэлт.** Энэ бүхнээс үзвэл монгол хэлт ард түмний бичиг үсгийн өөрчлөлт нь тэдний оюуны соёлын хувьд эерэг болон сөрөг байдлын аль алиныг бий болгодог байна. Эерэг тал нь монгол хэлт ард түмэн засаг захиргааны хувьд өөр өөр улс оронд харьяалагдаж байгаа гэсэн ч өөр өөрийн бичгийн хэлийг ямар нэг төвшинд хэрэглэж байгаа нь хэл, соёлоо хамгаалах, хөгжүүлэх боломжийг бий болгож байна. Сөрөг тал нь монгол хэлт ард түмэн өөр өөрийн зөв бичих дүрэм бүхий бичгийн хэлийг хэрэглэж байгаа нь тэдний хэл аялгуу, оюуны соёлд зааг ялгаа үүсэх, зарим хэсэг нь харьяалагдсан орныхоо хэл, соёлд аажим боловч автах нөхцөлийг бий болгодог байна. Иймд цаашид дундын нэр томъёо тогтоох, соёлын талаар ойртоход ахиц гаргах нь чухал юм.

Одоо үеийн монголчуудын бичгийн хэлний ийм байдал нь зарим талаар тэдний хэл аялгууг ангилах шалтгаан болдог байна. Үүний бодит жишээ нь монгол хэл аялгууг судалж ирсэн түрүү үеийн эрдэмтэд салангид монгол хэл, аялгууг үүнд хамааруулаагүй боловч төв монгол

хэлний аялгуунуудыг нэг эх монгол хэлний нутаг нутгийн аялгуу, аман аялгуунууд гэж үзэж байсан бол дараа үеийн нэлээд судлаачид ойрын болон холын төрөл монгол хэлнүүд, эсвэл төрөл монгол хэлнүүд гэж хуваан тэмдэглэж байна.

Иймд одоо үеийн бичгийн хэл бүхий монголчууд засаг захиргааны хувьд тусгай байх улс төрийн эрх үүргээс гадна өөр өөрийн аялгуунд суурилсан бичгийн хэлийг хэрэглэх болсон нь тусгай “хэл” гэж нэрлүүлэх нэг шалтгаан болж, өмнө өгүүлснээр тэдний хэл аялгууны хооронд төдийгүй нэг аялгууны хувьд ч зааг ялгаа гарах байдал бий болсон байна. Тухайлбал, монгол улсын буриад аялгуу нь уламжлалт буриад аялгууныхаа онцлогийг хадгалахын сацуу үгийн сангийн хувьд орчин цагийн монгол хэлэнд бий болж буй бичгийн хэлний үгийн сангаар баяжиж төв монгол хэлний нэг аялгууны байдлыг хадгалж байгаа бол орос улсын бүрэлдэхүүнд багтаж буй буриад монгол улсын бичгийн хэл нь буриад монголчуудын бичгийн хэлний шинэ тутам үүсэж буй онцлог байдлыг тусгахын хамт орос хэлний нөлөөгөөр хувирч өөрчлөгдөх, үгийн сан нь баяжих байдал бий болсон байна. Иймд одоо үеийн монголчуудын бичгийн хэлийг нэг эх монгол хэлний нутаг нутгийн бичгийн хэл гэж бас болох ажээ.

Бичгийн хэлийг хэм хэмжээ бүхий дүрэм журам, хөгжлийн үе шат нь энэхүү хэм хэмжээ бүхий дүрэм журмаасаа хамаардаг зүй тогтол гэж үзвэл ямар нэг ард түмний бичгийн хэлний хувьсал хөгжлийг заавал бичиг үсгийн өөрчлөлттэй холбож үзэх үндэслэл үгүй гэж болох юм. Монгол улс 1946 онд монгол бичгийг кирилл үсгээр сольж ярианы хэл болон орос үсгийн цагаан толгойг анхаарч зөв бичих дүрэм зохион гаргасан ч кирилл үсгийн бичгийн хэл нь бэлэн монгол бичгийн хэлний суурь дэвсгэр дээр уламжлан хөгжсөн билээ. Тод монгол үсэг болон халимаг монгол, буриад монголчуудын шинэ үсгийн бичгийн хэлийг ч ийм хууль зүйгээр тайлбарлаж болох байна. Иймд одоо үеийн монголчуудын бичгийн хэлийг тэдний хэдэн зуун жилийн өмнө бүтээн бий болгосон нэг бичгийн хэл, нэг эх монгол хэлний үргэлжлэл гэж болох юм.

**Одоо үеийн монголчуудын бичгийн хэлний соёлын холбоо нь соёлын бусад харилцаа холбооноос харьцангуй сул байдаг байна. Гэхдээ тэдэнд тогтвортой, цаг хугацаанд захирагдахгүй соёлын хэлхээ холбоо нь бичгийн хэлний соёлын холбоо гэдэг нь тодорхой юм.**

### ХАВСРАЛТ 1

**1. Монгол улс. Кирилл үсгээр:** Дува-Сохор магнай дундаа ганц нүдэт гурван нүүрийн газар харах бөлгөө. Нэгэн өдөр Дува-Сохор, Добун мэргэн дүүтэйгээ Бурхан Халдун дээрээс харваас Түнхэлиг горхи уруу нэгэн бүлэг иргэн нүүж ирж айсууг үзэж харж... (Д. Цэрэнсодном, 2000:31)

**2. Өвөр монгол. Худам монгол үсгээр:** ᠠᠲᠤ ᠰᠤᠬᠣᠷ ᠮᠠᠭᠨᠠᠢ ᠳᠤᠨᠳᠠᠭ ᠠᠨᠴ ᠨᠦᠳᠡᠲ ᠭᠤᠷᠪᠠᠨ ᠨᠦᠦᠷᠢᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ ᠬᠠᠷᠠᠬᠤ ᠪᠥᠯᠭᠡᠭᠡ. ᠨᠡᠭᠡᠨ ᠡᠳᠦᠷ ᠳᠤᠪᠤᠭᠠ-ᠰᠣᠬᠣᠷ, ᠳᠣᠪᠤᠨ ᠮᠡᠷᠭᠡᠨ ᠳᠦᠦᠲᠡᠢᠭᠡᠭᠡ ᠪᠦᠷᠬᠠᠨ ᠬᠠᠯᠳᠤᠨ ᠳᠡᠭᠡᠷᠡᠭᠡᠰ ᠬᠠᠷᠪᠠᠰ ᠲᠦᠨᠬᠡᠯᠢᠭ ᠭᠣᠷᠬᠢ ᠤᠷᠤᠭᠤ ᠨᠡᠭᠡᠨ ᠪᠦᠯᠭᠡᠭ ᠢᠷᠭᠡᠨ ᠨᠦᠦᠵᠢ ᠢᠷᠵᠢ ᠠᠶᠢᠰᠤᠶᠢᠭ ᠦᠵᠡᠵᠢ ᠬᠠᠷᠵᠢ... (Баяр 1980:5-9)

**3. Шинжааны ойрд монгол. Тод монгол үсгээр:** ᠳᠤᠪᠠ-ᠰᠣᠬᠣᠷ ᠮᠠᠭᠨᠠᠢ ᠳᠤᠨᠳᠠᠭ ᠠᠨᠴ ᠨᠦᠳᠡᠲ ᠭᠤᠷᠪᠠᠨ ᠨᠦᠦᠷᠢᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ ᠬᠠᠷᠠᠬᠤ ᠪᠥᠯᠭᠡᠭᠡ. ᠨᠡᠭᠡᠨ ᠡᠳᠦᠷ ᠳᠤᠪᠤᠭᠠ-ᠰᠣᠬᠣᠷ, ᠳᠣᠪᠤᠨ ᠮᠡᠷᠭᠡᠨ ᠳᠦᠦᠲᠡᠢᠭᠡᠭᠡ ᠪᠦᠷᠬᠠᠨ ᠬᠠᠯᠳᠤᠨ ᠳᠡᠭᠡᠷᠡᠭᠡᠰ ᠬᠠᠷᠪᠠᠰ ᠲᠦᠨᠬᠡᠯᠢᠭ ᠭᠣᠷᠬᠢ ᠤᠷᠤᠭᠤ ᠨᠡᠭᠡᠨ ᠪᠦᠯᠭᠡᠭ ᠢᠷᠭᠡᠨ ᠨᠦᠦᠵᠢ ᠢᠷᠵᠢ ᠠᠶᠢᠰᠤᠶᠢᠭ ᠦᠵᠡᠵᠢ ᠬᠠᠷᠵᠢ... (Dorba 1987:2)

**4. Халимаг монгол. Кирилл үсгээр:** Дува-Сокор магнадан ганц нүдт<sup>1</sup> болвчн, хурвн нүүдлин назрт хардг бил<sup>1</sup>. Нег өдр Дува-Сокор Добун-Меркан дүүл<sup>1</sup>-h<sup>1</sup> Буркан-калдун деер харв, Дува-Сокор Буркан-калдун деер<sup>1</sup>с харж, Түнкелик-хорькур нег бөлг иргн нүүж аашхиг



2. **Ж.Надмид**, Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм. Уб., 1967. **С.Мөөмөө, Ю.Мөнх-Амгалан**. Монгол хэл аялгуу. Уб., 1984. 345 тал.
3. **Г.Д.Санжеев**, Сравнительная грамматика монгольских языков. Том I., Москва., 1953. **Г.Д.Санжеев**, Сравнительная грамматика монгольских языков. Глагол. Москва. 1963. 266. **Б.Х.Тодаева**, Монгольские языки и диалекты Китая. М. 1960. **Д.Төмөртоогоо**, Монгол хэлний түүхэн хэлзүйн үндэс. Монгол хэлний түүхэн авианзүй. I. Уб. 1992. 419. **Чингэлтэй**, Дундад улс дахь монгол төрлийн хэлнүүд ба монгол хэлний аялгуунуудын ерөнхий байдал. –“Монгол хэл зохиол түүх”. Хөх хот. 1958. 1. 44-48. **Edited by Juha Janhunen**, -The Mongolic Languages. London and Neu York. 2003. 433. **N.Poppe**, Introduction to Mongolian Comparative Studies. Memoires De La Societe Finno-Ougrienne 110. Helsinki. 1955. 300.
4. **О.Самбуудорж**, Тод үсгийн бичгийн хэлний удиртгал. Осака. 2005:2-8. IX + 241.
5. **Daurica in Cyrillic Script. Re-edited by G.Kara**. Budapest 1995. Debter 10-11. (**Ааки** (Цагаан толгой). Хөххот. 1957.4 сар. 1-42. **Даудагу битэг** (Дуудах/унших бичиг). Хөххот. 1957.5 сар. 1-96. **Даур ургил** (Дагуур үлгэр). 1957.8 сар. 1-70. **Даур хэргэны жуугуу хийгу дурун** (Дагуур үсгийн зөв бичих дүрэм). Хөххот. 1957.4 сар. 1-47. **Даур учун, жаандаал** (Дагуур дуу, шүлэг). Хөххот. 1957.8 сар. 1-64. **Гэрэн гуруны ургил** (Олон гүрний/орны үлгэр). Хөххот. 1957 10 сар.1-159)
6. **О.Самбуудорж**, Тод үсгийн бичгийн хэлний удиртгал. Осака. 2005:39, IX + 241.
7. **Дьердь Кара**, Книги монгольских кочевников. Москва., 1972. 195 + 26. **Tchoi.Loubsanjav**, A Propos de l'Orthographe du Mongol en Alphabet Latin – Etudes Mongoles Si'beriennes Cahier 16, 1985, 107 -115. **Christopher Atwood**, A Proposed Latin Transcription System for Modern Mongolian – ОУМЭ-ний VIII Их хурал. II боть. Уб. 2002. **Michael Balk**, Transliteration and Romanization of the Mongol Script –The Seventh International Congress of Mongolists, volume II. 1997. **Ч.Дорсүрэн**, Монгол газар усны нэр тэмдэглэх болзмол цагаан толгой. –“Монгол хэл бичгийн судлал” IX. ШУА. ХЗХ. 2000. 82-90. **Ц.Шагдарсүрэн**, Латин үсэг. –“Монголчуудын бичиг үсгийн товчоон. Уб. 2001 181-188. **T.Jamcha**, Internet svljeend keregledeg Oirod keleni Latin vsvgiin cagaan tolgoi bolon zo'b bichilge in zarim arga –Akad. D.Tomertogoogiin 70 nasnii oid. 2008.
8. **О.Самбуудорж, Г.Даваажав**, Даяаршил хийгээд Монгол хэл аялгуу. –“Шинжлэх Ухаан Технологи ЭШС”. 2010. №2. 30-34

### Б. ХАВСРАЛТЫН НОМ ЗҮЙ

1. (Цэрэнсодном 1990), -Монголын нууц товчоо, эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Уб. 2000. 386.
- (Баяр 1980), -1.  $\text{ᠮᠣᠩᠭᠣᠯᠤᠨ ᠨᠢᠶᠦᠴᠢ ᠲᠣᠪᠴᠢᠶ᠋ᠠᠨ ᠲᠡᠷᠢᠭᠦᠨ ᠳᠡᠪᠲᠡᠷ ᠪᠣᠪᠦᠷ ᠮᠣᠩᠭᠣᠯᠤᠨ ᠠᠷᠠᠳᠤᠨ ᠪᠡᠯᠡᠯᠡᠭᠤᠨ ᠬᠣᠷᠢᠶ᠋ᠠ}$ , (Mongyol-un niyuča tobčiyān, Terigün debter, Öbür mongyol-un arad-un keblel-ün horiy-a. 1981)
- (Дорба 1987), -1.  $\text{ᠮᠣᠩᠭᠣᠯᠤᠨ ᠨᠢᠶᠦᠴᠢ ᠲᠣᠪᠴᠢᠶ᠋ᠠᠨ - ᠴᠢᠩᠭᠢᠰ ᠬᠠᠨᠢ ᠰᠢᠶᠠᠲᠠᠷ ᠰᠢᠩᠵᠢᠶᠠᠩᠭᠢᠶᠢᠨ ᠠᠷᠠᠳᠢᠶᠢᠨ ᠪᠡᠯᠡᠯᠡᠭᠤᠨ ᠬᠣᠷᠣᠳᠤ}$ . (Kö. Dorba orčuulba, Mongyol-yin nuuča tobčiyān. -Činggis xāni šaštar, Šinjiyang-giyin aradiyin keblel-in horō).
1. (Дарваев 1990), -Сокровенное сказание монголов. Анонимная монгольская хроника 1240 года. (Составление, вступительная статья, примечания, перевод на калмыцкий и русский языки П. А. Дарваев). Элиста. Калмыцкое книжное из-во. 1990. 280.
2. (Чимитов 1990), -Сокровенное сказание монголов, Анонимная монгольская хроника 1240 года. (Перевод на бурятский Г.Г.Чимитов). Элиста. Калмыцкое книжное из-во. 1990. 280.